



ТӨВ АЙМАГ  
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/103

Бүрэн сум

Коронавирусын тархалтын үед авч хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дахь заалт, 29.2, 29.3 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, 10.7 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд болон сургуулийн сурагчдын дунд Коронавирусын тархалт багасаж байгаатай холбогдуулан Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн танхимын хэлбэрт шилжүүлсүгэй.

2.Танхимаар хичээлэх үед сурагчдын халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан анги танхимд ариутгал цэвэрлэгээг тогтмол хийж, ойрын хавьтлаар тогтоогдсон сурагчдыг гэрийн тусгаарлалтад 14 хоног шилжүүлж, холбогдох бусад арга хэмжээ авч ажиллахыг Цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сайнбаяр), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (С.Одгэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Отгонхишигт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

410500268